

**Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл**



# **Зөвлөлийн ажил, уялдаа холбоо, хэтийн чиг бодлого**

**2016 үйл ажиллагааны төлөвлөгөө болон  
2017-2020 оны хэтийн чиг хандлага, зорилтууд**

*/төсөл/*

**2016-2020**

## **1. Нийтлэг үндэслэл, зөвлөлийн зорилго**

## **2. 2016 оны үйл ажиллагааны хураангуй**

## **3. 2017-2020 үйл ажиллагааны хураангуй**

## **4. Ойрын хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөө**

- 4.1. Хилийн чанад дахь ТББ-уудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх
- 4.2. Эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилт
- 4.3. Монгол хэл, соёлыг хилийн чанадад сурталчлах, өвлүүлэх
- 4.4. Сайн дураар эвлэлдэн нэгдэхийг дэмжих, оюутан залуусыг уриалан оролцуулах
- 4.5. Хилийн чанад дахь иргэдийн үүсгэн санаачилгыг дэмжих
- 4.6. Соёл урлагийн асуудал бодлогын талаар
- 4.7. Бизнес эрхлэлтийг дэмжих талаар явагдаж буй ажлуудын талаар бизнесийн хороо хэрхэн ажиллах бодлого гаргах.
- 4.8. Хилийн чанад дахь Монгол номын санг дэмжих
- 4.9. Нийгмийн бодлогын хэлтэс байгуулах
- 4.10. Спортын дэд хороог тусгайлан үүсгэх тухай

## 1. Нийтлэг үндэслэл, зөвлөлийн зорилго

Хилийн чанадад дахь Монголчуудын Зөвлөл ТББ нь 2014 оны 9 дүгээр сарын 18 -нд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдсан „Бүтээлч хамтын ажиллагаа“ - Хилийн чанадад дахь монголчуудын ТББ-уудын анхдугаар чуулга уулзалтын дараа „Зөвлөл“ байгуулан хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, Монгол улсын төр, засгийн байгууллагуудтай харилцах үйл ажиллагаагаа оновчтой хэлбэрт орох нь зүйтэй хэмээн санал нэгтэй нэгдэн үүсгэн байгуулагджээ.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын Төр засгийн зүгээс хилийн чанад дахь Монголчуудын асуудалд анхаарал хандуулж, төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж буй нь сайшаалтай ч хилийн чанад дахь Монгол иргэд та БИДНИЙ үүсгэл санаачлагын байгууллагуудын хамтын ажиллагаа, эв нэгдэл, нэгдсэн зохион байгуулалт, хамтарсан дуу хоолой ямар ч сайн санаачлагыг амжилттай хэрэгжих үндэс суурь болох юм.

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн зорилго нь Хилийн чанад дахь Монгол иргэд, тэдний холбоо, байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээн сурталчлах, гишүүн байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэдгээрийг чадваржуулах, төсөл хөтөлбөрөөр дамжуулан дэмжлэг үзүүлэх зорилго чиглэлийг баримтлан ажиллахаар тодорхойлогдож буй билээ.

## 2. 2016 оны үйл ажиллагааны хураангуй

### 2016 оны 1, 2 сард хийгдсэн ажлын чиг бодлого

- Өөр хоорондоо харилцан мэдээлэл, туршлага солилцох, нэгдсэн сүлжээг бэхжүүлэх
- Хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, үйл ажиллагаагаа уялдуулах үндэс суурийг бэхжүүлэх, нэгдсэн ойлголт өгөх
- Зөвлөлийг ил тод байлгах, бүтэц, үйл ажиллагааг жигдрүүлэх
- Үйл ажиллагааны бодлого, зорилго, харилцааг тодорхойлох

### 2016 оны эхний хагас жил

- Нийт хилийн чанад дахь бүх ТББ, нэгдэлүүдтэй холбоо тогтоон ажиллах. тив, улс бүрийн төлөөлөө тэнцвэрт байдалд анхаарах
- Монгол улсад болон Олон улсын холбогдох байгууллагуудын гишүүнээр элсэх нөхцөл, шаардагыг судлан, тавигдах шаардагуудыг бүрдүүлэх
- Дэлхийн Монголчууд хөтөлбөр, Зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулах талаар бүс нутгийн чанартай уулзалт зөвлөгөөн зохион байгуулах
- Тогтмол сэдвээр онлайн уулзалтуудыг зохион байгуулж, шийдэл гаргаж хэвшүүлэх
- Онлайн мэдээллийн тогтмол дугаар гаргах

Чиглэл чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, нэгдэлүүдийг зорилтот аян, төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлэх  
Үүнд : 2016 оны 3 сард багтаан Монгол хэл, сургуулийг дэмжих

- **„Эх хэл, соёлоо дэмжих“ аянаар эхлүүлэх**
- Хилийн чанад дахь Монгол номын санг дэмжих ажлыг эхлэх
- Шилэн данс онлайн хөтлөн хэрэгжүүлсэн аян, төсөл хөтөлбөрийн санхүүжилт орлого, буцаан зарцуулалт, хаана хэрхэн дэмжлэг үзүүлсэн ил тод байдлыг ханган ажиллах

## **2016 оны 2-р хагас жил**

- Гишүүд, ТББ-ууддаа аян, төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжүүлэх / Шилэн дансаар санхүүжилт орлого, буцаан зарцуулалт, хаана хэрхэн дэмжлэг үзүүлсэнг ил тод байлгах /

- **Хилийн чанад дахь ТББ-уудын мэдээлэл**

Хилийн чанадад буй Монголчуудынхаа түүхийг өгүүлэх товхимол гаргах

- ТББ Мэдээллийн санг бүрдүүлнэ.
- Тогтмол мэдээллийн дугаар гаргана.
- Хилийн чанад дахь ТББ уудын түүхэн ном гаргана.
- Хойшид хийж буй хэрэгжүүлж буй ажлуудыг сурталчилсан жил, хоёр жилд цувралууд гарган ажиллуулна.

- **Хилийн чанад дахь бодит мэдээлэл түгээх**

Ташаа мэдээлэлд автан хилийн чанадад эрсдэл гарган зохион ирээд хэрэг төвөгт орох, эрх нь зорчигдож буй иргэдийн асуудлаар мэдээллийн материал гаргах, түгээх, цаашлаад нийгмийн асуудлын хороог үүсгэн байгуулж үйл ажиллагааг тогтворжуулна.

- **Хилийн чанад дахь Монголчуудын хоёр дахь чуулга уулзалт**

ГХЯ-тай хамтран „Хилийн чанад дахь Монголчуудын хоёр дахь чуулга уулзалтыг 2016 оны 9 сард зохион байгуулна.

- Сүүлийн 2 жилд зохиогдсон шилдэг арга хэмжээнүүдийн талаар тайлагнана. / Шилдэг Төрийн бус байгууллага, холбоо, сургууль гэсэн тодорхойлолт урамшуулал бий болгох /
- Төр засгийн бодлогод тусган оруулах асуудлаар нэгтгэн дэвшүүлж буй саналуудаа хүргэнэ.
- Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн Удирдах зөвлөлийн ээлжит сонгууль / Хяналтын алба байгуулах /
- УЗ-бусад шаарлагатай бүс, нэгдсэн холбоодоос төлөөлөл нэмж оруулах

### 3. 2017-2020 үйл ажиллагааны хураангуй

- Хилийн чанадаас эх орны хөгжилд хувь нэмрээ оруулах аливаа үйл ажиллагааг дэмжих тогтсон арга замтай болох
- патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд монгол эрдэмтэд, өндөр мэргэжил эзэмшсэн иргэд, тэдний ажилладаг болон хамтран ажилладаг байгууллага, ТББ уудыг татан оролцуулах
- Эргэн сууршилтын бодлогод зөв бодлого, шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлэхэд шийдэл болох санал санаачлагыг нэгтгэн дэвшүүлдэг байх
- Монгол улсад болон Олон улсын холбогдох байгууллагуудын гишүүнээр элсэн орсноор
  - Хилийн чанад дахь зохиолч, уран бүтээлчидийн оюуны өмч
  - Иргэд, ТББ-уудынхаа эрхийг олон улсын хэмжээнд хамгаалах эрх зүйн чанамж бүхий байгууллага болох
- Хилийн чанадад буй Монголчуудынхаа хийж буй ажлуудыг сурталчлан таниулдаг нэгдсэн дуу хоолой нь болох
  - Чанартай мэдээллийн баг бүрдүүлэн Монгол улсад Хилийн чанад дахь Монголчуудын мэдээллийн цагын хүрдийг тогтмол гаргах
- Тивийн хэмжээнд спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх сан үүсгэх
- Иргэд, ТББ –уудын ирүүлсэн санал санаачилга, нөөц бололцоог дэмжиж ажиллах тогтсон зам, аргалал үүсгэх
- Уламжлалт арга хэмжээнүүдийг дэмжин ажиллаж, дэлхийн Монголчуудын урлаг, спортын наадам зохион байгуулах

## 4. Ойрын хугацаанд хийгдэх ажлуудын талаар төлөвлөгөө

### Үндсэн зарчим, бодлого

- Өөр хоорондоо харилцан мэдээлэл, туршлага солилцох, нэгдсэн сүлжээг бэхжүүлэх
- Хоорондын хамтын ажиллагааг зохицуулах, үйл ажиллагаагаа уялдуулах үндэс суурийг бэхжүүлэх
- Зөвлөлийг ил тод байлгах, үйл ажиллагааг тогтворжуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 1 дугаарын тогтоолоор Дэлхийн Монголчууд хөтөлбөр, Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр батлагдсан мэдээгээр зөвлөлийн шинэ оны үйл ажиллагаа эхэлж буйгаараа онцлогтой юм.

Тус хөтөлбөр 2016-2020 онд хэрэгжих бөгөөд энэ хөтөлбөр төдийгүй шинээр батлагдсан Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөрт зөвлөлийн буюу та бидний үүрэг роль өндөрөөр тавигдаж буй билээ.

Цаашид **„Иргэн бүр элчин сайд“** – уриан дор бүтээлчээр хамтран ажиллах аваас манай Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл жинхэнэ утгаараа хилийн чанад дахь холбоод, иргэдийн төлөөлөл болон итгэл хүлээсэн байгууллага болох бөгөөд энэ нь та бидний энэ жилийн идэвхтэй үйл ажиллагаатай салшгүй холбоотой тавигдаж буйг дурдахыг хүсэж байна.

#### 4.1. Хилийн чанад дахь ТББ-уудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх

Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн

6.1. Хилийн чанадад байгаа иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бий болгож, иргэний бүртгэлд бүрэн хамруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.1.3. хилийн чанадад амьдарч байгаа иргэдийн талаар сэдэвчилсэн судалгаа хийж, үр дүнг Улсын Их Хурал, Засгийн газарт зохих журмын дагуу танилцуулж, бодлого, төлөвлөлтөд ашиглах;

Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн 6.1 д тусгагдсан Хилийн чанадад байгаа иргэдийн мэдээллийн нэгдсэн сан бий болгох ажлын суурь болгох зорилго бүхий

- Хилийн чанад дахь ТББ-уудын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх,
- ТББ-уудад шаардлагатай мэдээллийн булан сан үүсгэх

Үүнд:

- Тогтмол мэдээллийн онлайн, хэвлэмэл товхимол дугаар
- Хилийн чанад дахь ТББ-уудын түүхэн ном
- Хоёр жил тутмын хэрэгжүүлж буй ажлуудыг сурталчилсан товхимол
- Эрх нь зөрчигдсөн иргэд болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн санал хүсэлтийг хүлээн авдаг, зөвлөгөө өгдөг, шаардлагатай нөхцөлд туслах, холбогдох газруудад уламжлан ажилладаг тогтолцоог бүрэлдүүлэх
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамгийн эхний бодит ажил болох мэдээллийн гарын авлагыг 2016 оны эхний хагас бэлэн болгон гаргах, цаашид тараах хэлбэрийг өргөжүүлэх арга замыг тодорхойлох



## 4.2. Эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх зорилт

Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн

6.2.4. патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд монгол эрдэмтэд, өндөр мэргэжил эзэмшсэн иргэд, тэдний ажилладаг болон хамтран ажилладаг байгууллагыг татан оролцуулах

- Бизнесийн Хөгжлийн Хороо, Соёлын менежмент, аялал жуулчлалын хорооноос Цахим өртөө ТББ –тай хамтран **"Монгол орны хөгжилд" 12 дахь удаагийн чуулга уулзалтыг**
  - "Бүтээлч үйлдвэрлэл" сэдвийн дор 5 сарын 1-нд Франц улсын Парис
  - "Гадаад дахь бизнес эрхлэлтийн орчин туршлага" сэдвийн дор 6 сарын дундуур Канад улсын Торонто хотодтус тус зохион байгуулах

Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн

6.4. Монгол иргэдийн холбоо, иргэдийн санаачилгыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.4.5. төрийн байгууллага болон хилийн чанадад байгаа иргэд, эх орондоо байгаа иргэдийн хооронд харилцах нэгдмэл ойлголт, байр суурийг бүрэлдүүлэх;

- **Хилийн чанад дахь ТББ-уудын бүсийн уулзалтыг зохион байгуулах**

*„Дэлхийн Монголчууд“, „Монгол улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр“ - үүдийн талаар дэлгэрэнгүй сурталчлах, гишүүн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллага болон хилийн чанадад байгаа иргэд, эх орондоо байгаа иргэдийн хооронд харилцах нэгдмэл ойлголт, байр суурийг бүрэлдүүлэх болно*

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулах, ил тод байлгах, мэргэжлийн үйл ажиллагаатай болгож ажиллуулах талаар холбогдох газруудад хандан зөвлөгөө үзүүлэх, бүсийн уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт гаргах

### **4.3. Монгол хэл, соёлыг хилийн чанадад сурталчлах, өвлүүлэх**

#### **Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн**

6.4.4. хилийн чанадад байгаа монгол хүүхдүүдэд монгол хэл, ёс заншил, түүх, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх байгууллагад сурах бичиг, гарын авлага, хялбаршуулсан сургалтын хөтөлбөр зэргээр дэмжлэг үзүүлэх нөхцөл, шалгуурыг боловсруулж Засгийн газраар батлуулах;

Боловсролын хорооноос хилийн чанад дахь бүх энэ чиглэлийн, сургууль нэгдлүүдтэй холбоо тогтоон ажиллаж, шинэчилсэн бодит судалгааг гаргахаар идэвхтэй ажиллаж байна. Иймд:

- Хилийн чанадад Монгол хэл заах, сурах бичиг боловсруулах хөтөлбөрийн ажлын хэсэгт гадаадад ажиллаж буй багш нарын хамруулан оролцуулах талаар тодорхой нэр бүхий хүсэлт санал дэвшүүлж байна./ Тив, улс бүрийн онцлогийг тусгах, оролцооны тэнцвэрт байдлыг хадгалах

### **4.4. Сайн дураар эвлэлдэн нэгдэхийг дэмжих, оюутан залуусыг уриалан оролцуулах**

#### **Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн**

6.4. Монгол иргэдийн холбоо, иргэдийн санаачилгыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.4.1. хилийн чанадад байгаа монгол иргэдийн холбоод ардчилсан, ил тод зарчмаар, сайн дураар эвлэлдэн нэгдэхийг дэмжих;

Монгол иргэд, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, эв нэгдэл, нэгдсэн зохион байгуулалт, хамтарсан дуу хоолой ямар ч сайн хөтөлбөрийн амжилттай хэрэгжих үндэс суурь болох билээ. Иймд

- 2016 оны 9 сард зохион байгуулахаар төлөвлөж буй Хилийн чанад дахь Монголчуудын ТББ-уудын 2-р чуулга уулзалтыг ГХЯ ивээлдээ оруулан хамтран зохион байгуулах

- Дагалдах уулзалтаар Оюутан Залуучуудын хорооноос ирээдүйд олон зүйлийг Монголдоо хийхээр суралцаж байгаа залуусыг нэгдсэн бодлоготойгоор дэмжих өдөрлөг зохиох, тодорхой үүрэг чиглэл гаргах
- Ирээдүйд оруулж буй том хөрөнгө оруулалт болох „Байнга идэвхитэй үйл ажиллагаа хийж, оюутан залуучуудыг идэвхижүүлэхэд тодорхой хэмжээний төсөв гаргаж өгдөг байх,“ тогтолцоог бүрдүүлэх талаар ажиллах
- Хилийн чанад дахь Оюутан Залуучуудын хороог Монголын залуучуудын холбоо болон Монголын Оюутны холбоотой үйл ажиллагааг уялдуулах талаар анхаарч ажиллах.

#### **4.5. Хилийн чанад дахь иргэдийн үүсгэн санаачилгыг дэмжих**

6.4.2. хилийн чанадад байгаа монгол иргэд уулзалт зохион байгуулах, хот, улс, тивийн хэмжээнд спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, дэлхийн монголчуудын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах;

6.4.6. дипломат төлөөлөгчдийн газраас иргэдийн холбоог дэмжиж, иргэдтэй нээлттэй, тогтмол харилцах тогтолцоог хэвшүүлэх.

6.5.2. монгол хэл, соёл, урлаг, зан заншлыг тээгч ард түмнүүд, монгол иргэд харилцах, соёлын өвийг хамтран сурталчлах, шинжлэх ухааны судалгаа хийх, эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, соёл урлаг, спортын олон улсын арга хэмжээ зохион байгуулах зэрэг хамтын ажиллагааг дэмжих;

- Тивийн хэмжээнд спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх сан үүсгэх
- Соёлын төрөл бүрийн салбарын үйл ажиллагааг хамарсан “Монголын гэр музей”, „Монголын соёлын төв” байгуулах иргэд, ТББ –уудын ирүүлсэн санал санаачилга, нөөц бололцоог дэмжиж ажиллах төлөвлөгөөг боловсруулж, уулзалт зохион байгуулах, бэлтгэх

#### **4.6. Соёл урлагийн асуудал бодлогын талаар:**

- Монголчуудын зөвлөлөөс ГХЯ ны дэмжлэгтэйгээр болон мэргэжлийн байгууллагуудыг зөвлөгөө, лекц оруулсан Монгол улсыг гадаадад сурталчлах соёлын бодлого булан үүсгэх
- Монгол соёлын арга хэмжээ зохион байгуулахад анхаарах зүйл, хэрхэн нийтэд зөв хүргэх зөвлөгөө гаргах, өдөрлөг зохион байгуулах, цахим хуудасд тусгай булан үүсгэх (жишээ нь Монгол наадам гэхэд дэг жаяг, ёс журмыг сайн мэдэхгүй, гадаад хүн асуухад тайлбарлаж сурталчлах юмгүй наадмууд олон бий)
- Нийтлэг гардаг хүндрэлтэй асуудлаар мэдээллийн булан үүсгэх / Жишээлбэл ашиглаж болох зураг, видео, дуу

Хилийн чанадад хөгжиж буй урлагын холбоо, нэгдэлүүдийг дэмжиж ажиллах, тэдний хамтын ажиллагааг идэвхжүүлэх, цаашдаа 4 жилд нэг удаа **„Хилийн чанад дахь Монголчуудын Урлаг - Спортын наадам“** хийх эхний наадмыг 2020 онд зохион байгуулах зорилготой ажиллах

#### **4.7. Бизнес эрхлэлтийг дэмжих талаар явагдаж буй ажлуудын талаар бизнесийн хороо хэрхэн ажиллах бодлого гаргах.**

- Гадаадад Монгол орны эдийн засгийн нөхцөл болон хөрөнгө оруулалтын орчны талаар зөв зүйтэй, эерэг мэдээлэл хүргэж байх талаар ТББ, холбоодод мэдээллийн булан, Монголыг сонирхсон гадаад иргэдийн нийтлэг тавьдаг асуудлаар мэдээллийн булан үүсгэх
- Тодорхой арга хэмжээнд Бизнес хөгжлийн хорооноос төлөөлөн оролцох чадвартай мэргэжилтэнүүдийн бааз үүсгэх, мэдээллээр хангах ажил зохион байгуулах эхлэл тавих талаар анхааран ажиллах
- Патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд монгол эрдэмтэд, өндөр мэргэжил эзэмшсэн иргэд, тэдний ажилладаг болон хамтран ажилладаг байгууллагыг татан оролцуулах арга хэмжээг тогтмолжуулах дэмжих

#### **4.8. Хилийн чанад дахь Монгол номын санг дэмжих**

- Монгол сургуулиудад хүүхдүүддээ гэрээр ном өгч уншуулах номын хүрэлцээ, сан хүндрэлтэй байдаг юм байна. Иймд сургуулиудад Хүүхдүүдийн гэрээр авч унших номын сангийн фондод - хилийн чанад дахь найздаа - ном бэлэглэх аянг Монголд зөвлөлийн нэрээр өрнүүлж, фэйсбоок сошиал аар ашиглан хийх. Цугласан номыг сургуулиудад илгээх ажлын зохион байгуулах

#### **4.9. Нийгмийн бодлогын хэлтэс байгуулах**

Эрх нь зөрчигдсөн иргэд болон зорилтот бүлгүүдэд чиглэсэн санал хүсэлтийг хүлээн авдаг, зөвлөгөө өгдөг, шаардлагатай нөхцөлд туслах, холбогдох газруудад уламжлан ажилладаг тогтолцоог бүрэлдүүлэх

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамгийн эхний бодит ажил болох мэдээллийн гарын авлагыг 2016 оны эхний хагас бэлэн болгон гаргах, цаашид тараах хэлбэрийг өргөжүүлэх арга замыг тодорхойлох
- ТББ албан ёсны бүртгэлтэй байх талаарх давуу тал, боломж гэх талаас нь харуулсан уриалга, зөвлөмж гаргах
- Нийтлэг тавигддаг асуудлаар мэдээллийн булан үүсгэх
- Гадаадад зорчих үед болон амьдарч байх үед бие муудсан үед эрүүл мэндийн даатгалаа хэрхэн ашиглах, хаана зөвлөгөө шинжилгээ авах илүү боломжтой байдаг, үйлчилгээ ямар үнэ ханштай байхад дундаж үнэ байх талаар (наад зах нь шүд өвдөхөд) - аас эхлээд бодит тохиолдсон явдал дээр гарсан туршлагауд, хэрхэн цаг алдахгүй байх гэх мэт мэдээллийг орон бүрээр боловсруулан зөвлөгөө булан үүсгэн оруулах

2017-2020 онд эрүүл мэндийн салбарыг бие даасан хороо болгон өргөжүүлэх, энэ чиглэлийн эмч мэргэжилтэн нарын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

#### **4.10. Спортын дэд хороог тусгайлан үүсгэх тухай**

Хилийн чанад дахь Монголчууд маань сагсан бөмбөг, шагайн харваа, гар бөмбөгөөр уламжлалт тэмцээнүүдийг зохион явуулж шилдгүүдээ тодруулдаг төдийгүй хилийн чанадад Монгол улсаа эерэгээр сурталчлан таниулах, Монголын нэр нүүр болсон ирээдүйн залуусын хүмүүжил, алдарт тамирчид төрүүлэх, бэлтгэх их үйлст хувь нэмрээ зохион байгуулалтын өндөр төвшинд оруулж ирсээр нэлээдгүй жилийн нүүр үзэж байгаа билээ.

Харин жил ирэх бүр чанаржиж буй эдгээр тив тивийн уламжлалт тэмцээнүүдийг зохион байгуулахад гарч буй нийтлэг хүндрэл нь улам бүр хүрээгээ тэлж, өргөн олныг хамарч байгаа болохоор шаардлага хангасан заал, танхимыг олоход эдийн засгийн хүндрэл томоохон асуудлыг нэг болж байна. Иймд ач холбогдол дүүрэн энэхүү асуудалд төр засаг, холбогдох яамнаас анхаарлаа хандуулан тухайн жилд зохиогдох цөөхөн хэдэн уламжлалт тэмцээнүүдэд төсөв мөнгө тусгаж байх талаар

#### **Дэлхийн Монголчууд хөтөлбөрийн**

Монгол иргэдийн уулзалт зохион байгуулах, хот, улс, тивийн хэмжээнд спорт, соёл, урлагийн уралдаан зохиоход дэмжлэг үзүүлэх, Дэлхийн монголчуудын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах

заалтад уялдуулан

хилийн чанадад хөгжиж буй спортын холбоо, нэгдэлүүдийг дэмжиж ажиллах, тэдний хамтын ажиллагааг идэвхжүүлэх, цаашдаа тив улсын дунд явагдаад байгаа спортийн төрлүүдээс спортийн голчлон явагддаг төрлүүдээр 4 жилд нэг удаа **„Хилийн чанад дахь Монголчуудын Урлаг - Спортын наадам“** хийх эхний наадмыг 2020 онд зохион байгуулах зорилготой ажиллах